


БАТЛАВ
“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕР


Т.БАТМӨНХ

2024 оны 02 дугаар сарын 21



**МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР БАЙГУУЛАХ АЖИЛ - ЭҮТӨҮГ/202401011287
БАГЦ №1. НИЙЛЭГ ХАЛЬСАН ХҮЛЭМЖ БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР**

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.	Захиалагч компанийн нэр	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ
2.	Техникийн тодорхойлолт боловруулах зорилго	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 2031 он хүртэл 100 сая мод тарьж ургуулах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ногоон хөгжлийн төслийн нэгжийн 134 га газарт мод үржүүлгийн газар байгуулах
3.	Эрх зүйн үндэслэл	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлиг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 350 дугаар тогтоол, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, 2031 он хүртэл 100 сая мод тарьж, ургуулах, арчлан хамгаалах 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн батламж, үйлдвэрийн газрын 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан 2031 он хүртэл 100 сая мод тарьж, ургуулах, арчлан хамгаалах төлөвлөгөө, 2023 оны 09 сарын 06-ны батлагдсан Хангайн бүсийн ТЭЗҮ
4.	Талбайн нэр, байршил	Булган аймгийн Сэлэнгэ сумын III багийн нутаг, газрыг нэр Шар тал, Газрын гадаргуу тэгш. Налуу 1-2 градус, элсэрхэг хөрстэй 
5.	Ажлын хэмжээ	8м өргөн, 60 урт, 4 м-с багагүй өндөртэй 20 ширхэг нийлэг хальсан хүлэмж, иж бүрэн усалгааны системтэй
6.	Хууль зүй ба хуулийн хэрэгжилт	Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний бүхий л хүрээнд үйлчлэх Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор тавигдах шаардлагууд, мөн

		энэхүү бичиг баримтад тусгайлан заасан үйл ажиллагааны дүрэм, стандарт, бусад тогтоол, шийдвэр, журмууд, (зөвхөн үүгээр хязгаарлахгүй бусад) хууль тогтоомжоор дагаж гарсан шаардлагуудад нийцүүлж ажиллана.
--	--	--

2. ЗАХИАЛАГЧ БА ГҮЙЦЭТГЭГЧИЙН ҮҮРЭГ

1	Хүлэмж барихад мөрдөх стандарт	<ul style="list-style-type: none"> ✓ MNS-6636-2016 хүлэмжний стандарт; ✓ Бусад стандартууд
2	Төсөл хэрэгжүүлэгчид тавих шаардлага	<ul style="list-style-type: none"> ✓ Усалгаа болон хүлэмж угсрах талын 3 хүртэл жилийн ажлын туршлагатай байх, ✓ Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа тогтмол өгч ажиллах, ✓ Ажлыг гүйцэтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу ажил гүйцэтгэх графикийг гаргаж, зохион байгуулах
3	Хийгдэх ажлууд	<ul style="list-style-type: none"> ✓ Иж бүрэн хүлэмжний байгууламж угсрах ✓ Иж бүрэн усалгааны системийг суурилуулах
4.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	<ul style="list-style-type: none"> ✓ Ажлын байрны эрүүл ахуй, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн зардлыг тусгах; ✓ Баримтлах аюулгүй ажиллагааны дүрмүүд, стандартууд, сургалт зааварчилгаа, холбогдох зардлыг төлөвлөж тусгах
5.	Баталгаат хугацаа	3 жилээс багагүй
6.	Хяналт	<ul style="list-style-type: none"> ✓ Захиалагч тал ажлын гүйцэтгэлд графикийн дагуу хяналт тавих, ✓ Ажлын явц болон гүйцэтгэлийн хяналтын үед шийдвэрлэх асуудал гарвал Захиалагч болон Гүйцэтгэгч талын хариуцсан эрх бүхий албан тушаалтантай хэлэлцэж, хамтран шийдэх, ✓ Хамтран гаргасан шийдвэрүүдийг албан бичиг, хурал уулзалтын тэмдэглэлээр хоёр талаас баталгаажуулах

3. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үндсэн үзүүлэлтийн нэр	Ерөнхий шаардлагууд
1	Хэмжээ:	Нэг бүр нь 8м өргөн, 60 урт, (480м ²) 4 м-с багагүй өндөртэй 20 ширхэг хүлэмж
		<ul style="list-style-type: none"> ✓ Нуман нуруу ган хоолойн доод үзүүрийг газрын хөрсөнд 30-50 см-н гүнд зоож суурилуулах, ✓ Зэврэлтээс хамгаалсан цайрдсан ган хоолой байх, ✓ Хучлага болон хийцийн материал, төхөөрөмжийг даахуйц бат бөх, 25 кг/м²-с багагүй байх, ✓ Салхи тэсвэрлэх даац 25 м/сек-с багагүй байх, ✓ Нуман нуруу ган хоолойн голч 32 мм-с багагүй, зузаан 1,7 мм-с багагүй, хоорондын зай 0,6 м-с багагүй, ✓ Хөндлөн холбоос хоолой нь 7 ширхэг-с багагүй, голч нь 25,4 мм-с багагүй, зузаан 1,3 мм-с багагүй, ✓ Хажуу ханын өндөр 2,5м-с багагүй, ✓ Хажуу хананд механик төхөөрөмжөөр эвхэгдэж, буулгадаг 0,8-1,2 м-с багагүй нээлхийтэй байх, ✓ Бэхэлгээний гадас нь шовх үзүүртэй, дээд үзүүртээ нугалаас эсвэл гогцоотой, 10 мм-с багагүй голчтой, урт 80 см-с багагүй байх ✓ Хүлэмжинд гаднаас хортон шавж хог, шороо нэвтрэхээс хамгаалж нээлхийний дотор талд 1см² талбайд 25 ширхэгээс багагүй нүдтэй торон бүрхэвч татах, ✓ Хүлэмжийн байгууламжийн шалны түвшин нь орчны талбайн өндөржилтийн түвшнээс 0.1 метрээс багагүй өндөрт байх, ✓ Хүлэмжийн хаявчийн өндөр 0.3 метрээс багагүй байх,

2	Техникийн үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> ✓ Дээвэр нуман хэлбэртэй, налуугийн өнцөг хажуу ханатай харьцуулахад 42 градусаас хэтрэхгүй байх, ✓ Бүрхүүл хучлага нь нарны гэрэл сайн нэвтэрдэг, тунгалаг, хэт ягаан туяаны хамгаалалттай, дулаан барих чадвартай, усан дусал үүсгэдэггүй этилен винил ацетат нийлэг хальс /EVA/, полиолефин нийлэг хальс /PO/, нягтшил багатай полиэтилен нийлэг хальс /LDPE, LLDPE/, ✓ Нийлэг хальсны зузаан 0,15мм-с багагүй, -40 аас +40 хэмд физик шинж чанар алдахгүй, ашиглалтын хугацаа 3-с доошгүй жил байх, ✓ Хүлэмжийн 2 талын хаалганы өндөр 3,5м-с багагүй, өргөн 3 м-с багагүй, техник орох боломжтой, дүүжин байдлаар угсарч зориулалтын зам дээр хоёр тийш гүйж нээгдэж, хаагддаг байх, ✓ Хаалгыг 25мм×25мм-с багагүй хэмжээтэй, 1,5 мм-с багагүй зузаантай цайрдсан дөрвөлжин огтлолтой ган хоолойгоор хийх, ✓ Хүлэмж тус бүрийн 2 талын гадаад орчинд гэрэлтүүлэгтэй, асах унтрах цагийн тохиргоотой байх, ✓ Усалгааны системийг, хүлэмж бүрт насос /12,000 л/ц-с багагүй/, гол хоолой, туслах хоолой, мананжуулах системтэйгээр автомат удирдлага, цахилгаан хаалт, том болон нарийн хог шүүх 2 төрлийн филтэртэйгээр суурилуулах, ✓ Мананжуулагч усалгааны систем хүлэмжинд 4-н эгнээгээр, хошуу хооронд 1 м-с багагүй байх, ✓ Мананжуулагч толгой 4-с багагүй салаатай, дусал баригчтай /клапантай/, гуурсан хоолой, хүндрүүлэгч бусад холбох хэрэгсэлтэй байх, ✓ Ус нөөцлөх сав нь 50,000 л-с багагүй 2 ширхэг төмөр, гадна дотор тал нь зэврэлтээс хамгаалсан түрхлэг, зориулалтын будагтай, усны эх үүсвэртэй хоолойгоор холбогдох боломжтой ус юүлэх цорго хаалттай байх ✓ Ус нөөцлөх савыг газрын гадаргаас дээш 1м-с багагүй өндөрт, бат бөх суурьтайгаар байрлуулж, 10 хүлэмжинд 1 байхаар холбож суурилуулах , ✓ Үндсэн хоолойн диаметр 50мм- с багагүй, туслах хоолойн диаметр 25мм-с багагүй, ус юүлэгч, хий авагчтай байх, ✓ Үндсэн хоолойг хүлэмж хооронд болон ус нөөцлөх сав хооронд хөрсөнд суулгах, ✓ Хүлэмжний урт 40м-с их тул хүлэмжний хоёр нүүрэн талын дээд хэсэгт агаар сэлгэх сэнстэй, хүлэмжийн эзлэхүүнд тохирсон хүчин чадалтай байх, ✓ Сүүдрэвч нь нарны тусгалыг 55 хувь хүртэл бууруулах, салхи, бороо, хэт ягаан туяанд тэсвэртэй, дээврийг бүтэн хаах хэмжээтэй байх, ✓ Агаарын температур, чийг хэмжигчийг хүлэмж бүрт 3-5 ширхэг байхаар нарны тусгалаас хамгаалж хүлэмжийн төв хэсэгт, хөрсний чийг хэмжигчийг ургамлын ойролцоо хөрсөн дээр 12-с багагүй ширхэгийг байрлуулж, хяналтын самбар, шитнээс нэгдсэн мэдээлэл харах боломжтойгоор гүйцэтгэх, ✓ Хүлэмж хоорондын зай 4 м-с багагүй байх, ✓ Хүлэмж рүү ус орохоос хамгаалж эргэн тойронд 25 см-с багагүй шуудуу татах, ✓ Хүлэмжийн нийлэг хальсыг бэхлэхэд жийрэг хальс ашиглах ба 0,15мм-с багагүй зузаантай, -40-аас +40 градуст физик шинж чанараа алддаггүй байх ✓ Хүлэмжийн даруулга уяа нь дотроо сатурк гүйлгэж хүчитгэсэн полиэтилен уяа байх, нуруу бүрийн дунд даруулах
---	--------------------	---

		<ul style="list-style-type: none"> ✓ Хүлэмжийн нийлэг хальсны урагдсан цоорсон хэсгийг нааж битүүлэх зориулалтай материал болон цавуу сайтай хүлэмжний скоч хүлэмж бүрт 3-с багагүй ширхэгийг дагалдуулах
3	Шаардлага	<ul style="list-style-type: none"> ✓ Байгууламж нь барих ба ашиглах явцад эд ангийн орон зайн үл өөрчлөгдөх байдал, хөшүүн чанар, бат бэхийн шаардлагуудыг хангах ✓ Материал хийц нэг төрөл, үйлдвэрийн байх ✓ Барилгын бүтээц нь шууд болон сарнисан гэрэл бүрэн нэвтэрч, байрны температур нь огцом хэлбэлзэхгүй тогтмол байхаас гадна дулааны алдагдалгүй, температур-чийгшилийн горимыг тохируулах ердийн агаар солилцоотой байж, үйлдвэрлэлийн үйл явцыг механикжуулах нөхцлийг хангах, ✓ Усалгааны систем нь 5-с багагүй жилийн ашиглалт даах чанартай байх ✓ Хүлэмж бүрт усны хэрэглээний нормд тохирсон хүчин чадал бүхий насостай, филтьртэй иж бүрэн автомат тохируулгатай мананжуулагч усалгааны систем суурилуулах, ✓ Усалгаанд өгөгдсөн программтай удирдлагын хэрэгсэлтэй байх, ✓ Үндсэн болон туслах хоолой нь полиэтилен материалаар хийгдсэн хөнгөн, бат бөх, чанартай /PIPE/ хоолой байх, ✓ Хүлэмжийн ус хангамжийн оролт дээр усны тоолуур байрлуулах, ✓ Хүлэмжийн төв шугам салбар болон хүлэмжийн оролт бүр дээр хаалт тавих ✓ Хүлэмж нь агааржуулалтын системээр тоноглогдсон байх ✓ Цахилгаан техникийн төхөөрөмжүүдийг 220 кВ, түүнээс бага хүчдэлийн цахилгаан тоног төхөөрөмжтэй байх, ✓ Цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах, хүлэмж тус бүрт холболт, зангилааны хайрцагтай байх ✓ 10 хүлэмжинд бортоготой тарьц үржүүлэх зорилгоор 0,6м-н өндөр, урт 2м, өргөн 1,5м хэмжээтэй 3м² бүхий 1160 ширхэг тавцан байрлуулна. ✓ Үндсэн рамыг зэврэлтээс хамгаалж цайрдсан ган хоолой эсвэл квадратаар зангидаж (50мм-с багагүй), тавцанг 3см*3см-с ихгүй нүхтэй, 5мм-с багагүй диаметртэй гагнасан тороор хийж, 1 хүлэмжинд 116 ширхэгээр 4 эгнээнд байрлуулах ✓ Тавцан нь бортоготой хөрс даах даацтай байх /1м² тавцанд 550 кг-с багагүй/, голын хэсгийг хонхойж орохоос сэргийлж тулгуур хийх, хөлнүүдэд хөндлөн холбоостой байх

